



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 434

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 1 ширхэг суудлын автомашиныг 17,500,000.00 (арван долоон сая таван зуун мянган) төгрөгт багтаан барилгын техникийн хяналтын зардлын хэмнэгдсэн эх үүсвэрээр олж авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү, Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Саруултөгс нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002295

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дүгээр сарын 29-ны өдрийн
487 дугаар тогтоолын хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1500 cc	ш	1	17,500,000.00
	Дүн			17,500,000.00 (арван долоон сая таван зуун мянган)